



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 4/147

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.4, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.1.7 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний их баяр наадмын амралтын хугацаанд цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, мэдээ, мэдээлэл солилцох зорилгоор 2022 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 07 дугаар сарын 17-ны өдрүүдэд байгууллагын хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдын нэрс, холбогдох хуваарь, мэдээллийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд хяналт тавих албан тушаалтантай холбогдон шуурхай мэдээллээр хангаж, заавар, чиглэл авч, илтгэх хуудсаар баталгаажуулж дараагийн ээлжийн албан хаагчид хүлээлгэн өгч ажиллахыг хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэгч албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу нөхөн амрааж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

142022 02234